



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

# Төрийн албаны салбарын сургалт

# Гол асуудлууд

- Тоон болон чанарын судалгааны аргыг эзэмших зэрэг онолын мэдлэг олгох сургалтыг практикт ашиглахад чиглэсэн хэлэлцээ хийх, бичих ур чадвар зэрэг мэргэжлийн ур чадвар олгох сургалттай тэнцвэржүүлэх.
- Аливаа зөрүүг нөхөхүйц багшлах болон суралцах арга хэрэгслийг боловсруулах.
- Төрийн захиргааны боловсрол нь өргөн хүрээний сэдвийг хамрах боловч онол, практикийн аль алинд нь тулгуурлах ёстой.

## Канадын мужийн Засгийн газрууд төрийн захиргааны боловсрол, хөгжлийн талаар бидэнд юу зөвлөж байна вэ?

- Аливаа бодлогын шинжилгээнд хэрэгжилт, сонирхогч талуудын оролцоо, зардал зэрэг ойлголтуудыг тусад нь авч үздэг цаг үе ард үлдсэн.
- Бид бодит байдлыг тусгасан цогц мэргэжлийн хөтөлбөрийг санал болгох хэрэгтэй.
- Туршлагадаа тулгуурлан илүү амжилтанд хүрэхийг нь бататгах үүднээс төгсөгчидтэйгээ холбоотой байх
- Ажиллах хүчинд хөрөнгө оруулснаар хүртэх өгөөжийн талаар тодорхой ойлголтыг зөвхөн тухайн оролцогч төдийгүй ивээн тэтгэж байгаа эсвэл чөлөө олгон дэмжиж буй байгууллагад өгөх.

# Бүх Засгийн газраас ирүүлсэн санал дүгнэлтийг нэгтгэн үзвэл: Бодлого боловсруулах гурван элемент





# Төрийн үйлчилгээнд дараах шинж чанартай хүмүүс хэрэгтэй:

## • Өөрийгөө ухамсарласан

- Өөрийгөө, хэр уян хатан болохоо, өөрийн албан тушаал болон бусадтай харилцах харилцааныхаа байдлыг сайн мэддэг.

## • Манлайллын ур чадвартай

- Орчиноо мэддэг: Байгууллагаа болон нарийн төвөгтэй орчинг (улс төрийн, нийгэм-эдийн засгийн, технологийн болон олон улсын) ойлгодог.
- Өөрчлөлт, шинэчлэлтийг удирдах чадвартай: Алсын харааг тодорхойлж, үр дүнд хүрэхийн тулд стратеги боловсруулж, түүнийгээ эрхлэн гүйцэтгэж, эцсийг нь үзтэл явдаг.
- Нарийн төвөгтэй байдлыг зохицуулах чадвартай: Эсрэг тэсрэг чиг хандлагуудыг нэгтгэн, зохицуулж, тодорхойгүй ба ойлгомжгүй байдалд шийдвэр гаргадаг.
- Инновацийг дэмжигч: Шинэ санаа, бүтээлч байдал, тэдгээрийг эрсдэл гарган туршихыг хөхиүлэн дэмждэг орчныг бий болгодог.
- Хамтын ажиллагаа/харилцаа: Ажиллагсадтайгаа байнга харилцаатай, ижил түвшний хүмүүстэйгээ баг болж ажилладаг, гадаад орчны оролцогч талуудтай харилцаа, түншлэл бий болгодог.
- Харилцаа холбооны ур чадвар сайтай: Зөв газраа зөв санааг зөв дууны өнгөөр зөв сонсогчдод хүргэдэг.

- **Менежментийн ур чадвартай**
  - Хүмүүс, нөөц (хүний, санхүүгийн, материалын мэдээллийн, гүйцэтгэлийн менежмент), технологи, олон янз байдал, бусдаар дамжуулан удирдуулахын хэргийг хамгийн сайн гаргадаг.
- **Үнэ цэн ба ёс зүйтэй.**
  - Төрийн үйлчилгээний үнэ цэн ба ёсзүйг хэрэгжүүлж, үлгэрлэдэг, төрийн үйлчилгээнд нийтлэг байдаг ёсзүйн мухардмал байдлыг зөвөөр зохицуулдаг.
- **Төрийн үйлчилгээний үндэс суурийг сайн ойлгодог.**
  - Вестминстер загвар, Засгийн газрын зохион байгуулалт ба механизм, бодлого боловсруулах ба хууль тогтоох үйл явц, төлөвлөлт ба зарцуулалтын менежментийн үйл явц болон төв агентлагуудын үүрэг роль зэргийг ойлгодог.
- **Дэлхийн түвшинд авч үзэх хандлагатай.**
  - Дэлхийн түвшин болоод түүнд эзлэх Канадын байрыг өөрчилж буй динамик харилцан уялдаа холбоог мэддэг.

# Суралцах гэдэг нь төрийн албанд ямар утгатай вэ?

- Суралцах үйл явц нь хурдан тохиох ёстой.
  - *Суралцагчид асуудал нэгэнт тулчихаад байхад гүйцэтгэлийн менежментийн курсэд бүртгүүлж, гурван сар хүлээх сонирхол багатай л байх болов уу.*
- Суралцаж буй зүйл нь динамик, цагаа олсон байх ёстой.
  - *Суралцагчид өгөгдсөн ямар ч сэдвийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдээллийг хүсдэг.*
  - *Суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд богинохон бөгөөд голыг нь олсон сургалтын ажлууд хэрэгтэй.*
  - *Жишээлбэл, цахилгаан шатны найраа хэрхэн хийх талаар 30 секундын бичлэг.*
- Суралцаж буй зүйл нь хамааралтай байх ёстой.
  - *Таны ашиглаж буй энэ аргачлал нь хэр хуучин бэ?*



# Хэрхэн сургах үйл явцад гарч буй өөрчлөлт шилжилтийг удирдах нь

- Цахим орчинд богино бөгөөд хүчтэй контент илүү түгэж байна.
  - Бичлэг, зөвлөмж ба арга мэх, кейсийн судалгаа гэх мэт.
- Хүн бүрийг сургахаас илүүтэйгээр гол гол шилжилтийн цэгүүдэд нь сургахад төвлөрдөг болж өөрчлөгдөж байна.
  - Хянагч, менежер, удирдах албан тушаалтан байхын тулд ямар ямар ур чадваруудыг эзэмших шаардлагатай вэ?
  - Авьяасын менежментэд тулгуурлан сургах нь түлхүү болж байна.
- Агуулга нь суралцагчийн хувьд цагаа олсон, хамааралтай бөгөөд байнга сонирхол татахуйц байх.
  - Тухайн сэдвийн хувьд тулгарч буй асуудлуудыг хөнддөг, дэлхийн өнцөг булан бүрд түгсэн веб цацалтууд
- Түншлэл
  - Төрийн албан хаагчдад хамгийн тохирох контентийг авахын тулд хувийн хэвшил, эрдэмтэн судлаач, судалгааны байгууллагууд зэрэгт хандах хэрэгтэй.
  - Нарийн төвөгтэй асуудлын шийдэл нь Засгийн газар болон иргэний нийгмийн хоорондох үр дүнтэй хамтын ажиллагаа, харилцан үйлчлэлд тулгуурлахыг ойлгож ухамсарлах хэрэгтэй.

# Тулгарч буй сорилт

- **Мянганы үеийнхэн**

- Бүх өмнөх үеийнхнээс илүү их мэдлэг, ур чадвар, ухамсартайгаар ажиллах хүчний эгнээнд түрэн орж ирж буй мянганы үеийнхэнтэй бид хэрхэн харьцаж ажиллах вэ?

- **Шилжилт хөдөлгөөн**

- Ажиллагсад карьерынхаа туршид тухайн сектороос гадагш болон сектор дотроо олон удаа шилжих (хувийн хэвшлээс төрийн алба руу, дараа нь буцаад хувийн хэвшил рүү) бэлтгэгдсэн байгаа өнөө цагт олон шатлалтай байгууллагад үзүүлэх нөлөөлөл нь юу вэ?

- **Хамаарал**

- Мэдлэгийн ертөнц нь төрийн үйлчилгээнд нөлөөлж буй өөрчлөлттэй хөл нийлүүлж алхаж чадаж байна уу?